



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тэмдэглэл

2015.01.23

Тавантолгой

Хурал 2015 оны 01-р сарын 23-ны өдөр Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Тавантолгой ХК-ийн хурлын танхимд 14 цаг 00 минутанд эхлэн хуралдав.

Хурлын ирц хувьцаа эзэмшигчдийн тоогоор нийт 49471692 ширхэг буюу 93,9%-тай байна.

Хурлын дарга Б.Түвшинбаяр - ТУЗ-өөс гаргасан тогтоол, ТУЗ-д ирсэн ИТХТэргүүлэгчдийн тогтоол, хурал хуралдах болсон үндэслэлийг танилцуулав.

Б.Түвшинбаяр /Хурлын дарга/ - Хуралд хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Манай компани өөрөө орон нутгийн өмчит гэдэг утгаараа энэ хурал болохтой холбогдон ирсэн чиглэлийг уншиж танилцуулъя. / чиглэл уншиж танилцуулав/ Түүнчлэн та бүхэнд тарааж өгсөн материалд хурлын дэг, хэлэлцэх асуудалтай холбогдолтой бүх мэдээллүүдийг хавсаргасан байгаа. Та бүхэн уншиж танилцаад тодруулах зүйл байвал асуугаарай. Хурлын дэг, хэлэлцэх асуудлыг батлая. /Хурлын дэг хэлэлцэх асуудлыг уншиж танилцуулав/

Б.Түвшинбаяр /Хурлын дарга/ - Хэлэлцэх асуудал болон хурлын дэгд нэмэлт өөрчлөлт оруулах саналтай хувьцаа эзэмшигч байна уу. Хэрэв байхгүй бол хэлэлцэх асуудал болон хурлыг дэгийг батлах саналтай гишүүд саналаа өгнө үү. Хуралд оролцогсодын 100%-ийн саналаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг батлав. Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Өмнө та бүхэнд танилцуулж байсан албан бичгүүд, Өмнөговь аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2014.12.17 өдрийн 158 тоот тогтоол, Өмнөговь аймагт хөрөнгө оруулалтаар хийгдэж ажлууд болон бусад ажлуудад санхүүжилт хийгдэх, хөрөнгө санхүүгийн байдал хүндрэлтэй байгаа зэргээс шалтгаалан 2013 оны ногдол ашгийг 20% нэмэгдүүлж тараах талаар саналыг ТУЗ-д ирүүлсэн. ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд уг асуудлыг шийдвэрлэх боломжгүй учраас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулж уг асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэн хуралдуулж байна. Энэ тал дээр компанийн зүгээс болон хувьцаа эзэмшигчид та бүхний байр суурь ямар байгааг сонсох гэсэн юм. Хэлэлцэх асуудлын дараалал ёсоор компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн өнөөгийн байдлын талаар Гүйцэтгэх захирал Р.Сэддорж танилцуулна.

Гүйцэтгэх захирал – Р.Сэддорж – Та бүхний энэ өдрийн мэндийг хүргэн мэндчилж байна. Ээлжит бус хурлыг хуралдуулах болсон нөхцөл байдал болоод тухайн асуудалтай холбоотойгоор компанийн өнөөгийн нөхцөл байдал болон өнгөрсөн 2014 оны мэдээллээс танилцуулж байна. Манай компани 2014 онд Уулын ажлын төлөвлөгөө, ТУЗөвлөлийн баталж өгсөн бизнес төлөвлөгөөг бариж ажиллан 554,5 мян.тн нүүрс экспортонд гаргаж экспортын төлөвлөгөөг 29,1%, дотооддоо 91 мян.тн нүүрс борлуулж төлөвлөгөөг 101,1%-иар тус тус гүйцэтгэсэн байна. Уурхайн хэмжээнд нийт 4,6 сая.м куб хөрс хуулалтын ажлыг туслан гүйцэтгэгчээр хийж гүйцэтгэгчүүллээ. Нүүрсний гадаад зах зээл хямрал, Монгол улс дахь нүүрсний нөхцөл байдал хүнд, борлуулалтын үнийн уналт зэрэг олон хүчин зүйлийн

нөлөөллөөс экспортын борлуулалт бага байлаа. Дотоодод борлуулсан нүүрсний 6,3 мян.тн-ийг аймгийн төвийн нүүрс борлуулах цэгээр борлуулж, Өмнөговь аймгийн ИТХТ-ийн шийдвэрийн дагуу нүүрсийг 1 сарын хугацаанд 10%- ийн хямдралтайгаар нийт 21,04 мян.тн-ыг хэрэглэгчдэд борлуулсан байна. 2014 оны хувьд нүүрсний гадаад зах зээл дээрх үнэ оны эхнээс тасралтгүй унасан үзүүлттэй байгаа нь эрэлтийн хэмжээ буурсан, Хятад дахь төмөрлөгийн үйлдвэрүүд зогссон, агаарын бохирдлыг бууруулах бодлого хэрэгжүүлж Бээжин, Шиндун, Шансий зэрэг мужуудад байрлах нүүрс боловсруулах 1500 гаруй үйлдвэрийг хаасан, сүүлийн жилүүдэд дан ганц манай оронд бус худалдан авагчийн зах зээлд хүндрэл үүссэн зэрэгтэй шууд холбоотой. Компанийн хувьд 2014 онд хөрс хуулалтын ажлыг туслан гүйцэтгэгч 7 компанитай хуулийн дагуу хамтран ажиллаа. Уул геологийн нөхцөл жилээс жилд хүндрэх, шинээр авсан талбайд нэвтрэлт хийж голын талбайн нүүрсийг олборлохын тулд хөрс хуулалтыг ахуй хийх шаардлага тулгарсаар байна. 2014 оны хувьд борлуулалтыг нэмэгдүүлж дотоод зардлыг бага байлгах бодлогыг барьж ажилласан хэдий ч худалдан авагчын давуу байдал нэгэнт үүссэн, өрсөлдөгчөөс шалтгаалах нүүрсний үнийн уналт, нүүрс тээвэрлэлтийн шороон зам хаасан, өндөр үнэтэй замд гарахыг шаардаж эхэлсэн зэргээс шалтгаалан нүүрс борлуулалтын ажил төлөвлөсөн хэмжээнд хүрэлгүй ажилласан. Гэсэн ч уурхайн дотоодын зардлыг бага байлгах үүднээс ажил бага байгаатай холбоотойгоор ажилчдыг 60%-лах, туслах үйлдвэрлэлд гарч буй зардлыг бууруулах, үндсэн үйлдвэрлээс гадна орлого олох боломжит коксын үйлдвэрлэлийг ажиллуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Мөн цаашдын борлуулалтын ажлыг төлөвлөх, худалдаанд гаргах нүүрсний бэлэн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор ногдол ашгаас авч үлдсэн хөрөнгөөр хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж жилийн эхний байдлаар 450 орчим мян.тн нүүрсийг нээгээд байна. 2013 оны ногдол ашгийн 40,3 тэрбум төгрөгийг 2014 онд багтаан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан ба ногдол ашгийн өглөгийн хэмжээ одоогоор 10,7 тэрбум төгрөг байна. Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэн бодит нөхцөл байдлыг анхаарч дүгнэлт хийнэ гэдэгт тгэлтэй байна.

2014 онд нүүрсний үнэ тасралтгүй буурч зах зээлийн нөхцөл байдал хямралын түвшинд тулснаар нүүрс экспортлогч компаниуд зардлаа танах, нүүрсний экспортын тааламжтай байдлаа хадгалж үлдэхийн тулд дотоод нөөц бололцоогоо бүрэн дайчлан нүүрсний чанар стандартын мөрдөх, тээвэрлэлтийн асуудлыг хөнгөвчлөх зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна.

- Өрсөлдөгч байгууллага бүгд гүний гаальтай болсон учраас бид 2015 онд гүний гаалийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Ингэснээр тээвэрлэлтийн хувьд ижил түвшинд хүрнэ.
- Нүүрсний ангиллыг шинээр гаргаж өрсөлдөх түвшинд аваачих.
- Хэрэв 20% нэмж тараавал 12,5 тэрбум төгрөг болох бөгөөд тараасан тохиолдолд бэлэн мөнгөний хомсдолд орж хөрс хуулалтын ажлыг цаашид хэвийн тогтмол явуулахад хүндрэл гарч зээл авах хэмжээнд хүрнэ.

- Хэрэв зээлийг 1 сая тонн нүүрс гаргахад бэлэн хэмжээгээр бэлтгэхэд 5,2 сая.м3 хөрс буюу 24,4 тэрбум төгрөг болох бөгөөд 1 сарын хүү /1,5%/ 366,6 сая төгрөг төлж борлуулалт хийгдэхгүй байгаа тохиолдолд хүүгийн дарамтанд шууд орно.
- Зээл авахгүй тохиолдолд авлага барагдуулах ажил гүйцэд хийгдэж өрийг бүгдийг авсаны дараа үндсэн үйлдвэрлэлийн ажил явагдаж эхлэнэ. Шүүх шат, шийдвэр гүйцэтгэлийн шатанд 6-12 сар болж шийдэгдэх учир бүтэн жил “0” зогсолт хийнэ.

Эрхэм хувьцаа эзэмшигчидээ.

“Тавантолгой” ХК нь улс төр, нийгэм эдийн засгийн өөрчлөлтүүдийг шуурхай мэдэрч, зах зээлийн томоохон өөрчлөлтүүдэд бэлэн байхад та бидний хамтын ажиллагаа хамгаас чухал билээ. Та бүхэн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж гаргах шийдвэртээ тусгана гэдэгт итгэж байна. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Б.Түвшинбаяр /Хурлын дарга/ - Баярлалаа. Гүйцэтгэх захирлын тавьсан мэдээлэлтэй холбоотой асууж тодруулах зүйл байвал хувьцаа эзэмшигчид асууж болно. Асуулт байхгүй бол асуултаа таслаад саналдаа орох уу. Хуралд оролцогсодын 100%-ийн саналаар асуулт дуусгаж санал хэлэхээр болов. Санал хэлэх саналтай гишүүд саналаа хэлээрэй.

Л.Нямжав /хувьцаа эзэмшигч/ – орон нутгийн өмчийн зүгээс нэмж ногдол ашиг авах талаар санал оруулж байгаа юм байна. Компанийн нөхцөл байдал хүнд байгаа талаар гүйцэтгэх захиралын мэдээлэл дээр гарч байна. Бас нэлээд хэмжээний өр авлага байгаа юм байна. Хэрэв ногдол ашиг үүхээр тараахаар шийдвэрлэвэл авлага барагдуулах талаас нь хараад авлага болон ногдол ашгаа харилцан хаах зэрэг асуудлаар шийдвэрлэж боломж байгаа байх. Аймгаас авах авлага байгаа бол түүндээ тааруулаад ногдол ашиг нэмж тараах саналыг протоколд тэмдэглүүлэх саналтай байна.

Х.Хүүхнээ /хувьцаа эзэмшигч/ – 2013 онд хөрс хуулалт хийж уурхайн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор ногдол ашиг бага тарааж тодорхой хэмжээний хөрөнгө авч үлдсэн гэж ойлгож байна. Тийм учраас тэр хөрөнгөө хөрс хуулалтандаа зарцуулаад нэмж ногдол ашиг тараах асуудлыг дахин ярих шаардлагагүй гэж үзэж байна.

Д.Дагвадорж /хувьцаа эзэмшигч/ - Үнэхээр ногдол ашгийг 20% нэмж тараавал уурхайн нөхцөл байдал үнэхээр хүнд болно. Цаашдаа зогсонги байдалд орно. Түүнчлэн авлагаасаа хасаад ногдол ашиг тараана гэдэг бол ерөнхийдөө ямарч ялгаагүй зүйл. Орж ирэх байсан мөнгө орж ирэхгүй болоод мөн л адил зогсонги байдал байсаар л байх болно. Тийм болхоор авлага мөнгөөр нь авах хэрэгтэй. Өмнөговь аймгийн хувьд бас хүндрэлтэй болоод л уг асуудлыг оруулж ирсэн гэж ойлгож байгаа. Тиймээс бас тодорхой хэмжээгээр ногдол ашгийг нэмж хуваарилаад байгууллагад нөлөөлөл багатайгаар шийдэж аль аль талдаа хүндрэлийг шийдэх боломжтой гэсэн саналтай байна. Миний хувьд 5% нэмж тараах саналтай байна.

Г.Дамчий /хувьцаа эзэмшигч/ - Ингэхэд 2014 оны санхүүгийн үзүүлэлт ямархуу байдалтай гарсан байна. Тэр талаар дэлгэрэнгүй хэлэх боломжтой юу.

Р.Сэддорж / Гүйцэтгэх захирал/ - 2014 оны нөхцөл байдал хүнд байгаа. Зах зээл дээр нүүрсний үнийн уналт, өрсөлдөгч компанийн нөлөөлөл, уурхайн нөхцөл байдал зэргээс хамаараад

хямралтай байгаа. 2014 оны эцсийн байдлаар тайлан баланс гараагүй байгаа. Нөхцөл байдлын талаар мэдээллийг сая танилцуулсан байгаа. Хэдий хямралтай байгаа ч гэсэн орон нутгийн уурхай гэдэг утгаараа ажилчдын орон тоог цөөлөх, халах бодлого авалгүй ажилчдыг 60%-ийн цалингаар сул зогсоох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Л.Нямжав /хувьцаа эзэмшигч/ – Дагвадорж гуайн саналыг дэмжиж байна.

Б.Түвшинбаяр /Хурлын дарга/ - Өөр санал хэлэх саналтай хувьцаа эзэмшигч байна уу. Хэрэв байхгүй бол саналыг таслах саналтай байна. Нийт хуралд оролцогсодын 100%-ийн саналаар саналыг дуусгав. Санал дууссан учраас зарчмын хувьд нэг зүйлийг тохироод саналын хуудсаар саналаа аваад асуудлаа шийдвэрлэе. Хувьцаа эзэмшигчдээс гарсан ногдол ашгийг 5% нэмж тараах саналтай гишүүд нь саналын хуудсанд тэмдэглэл хийж саналаа өгөөх нь зүйтэй. Мэдээж татгалзах болоод түдгэлзэх саналтай хувьцаа эзэмшигчид тус тусын саналаа өгөх эрхтэй. Тооллогын комиссыг ТУЗөвлөлийн тогтоолд заасан байгаа. Тооллогын комиссын даргаар томилсон Б.Цэрэнпагма нь албан ажлаар томилолттой байгаа тул түүний оронд Тавантолгой ХК-ийн хуулийн зөвлөх С.Одонтуяаг томилон ажиллуулж байна. Тооллогын комиссын зүгээс саналын хуудсыг тарааж тайлбар мэдээллийг өгнө.

С.Одонтуяа /Тооллогын комиссын дарга/ - хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналын хуудсыг хэрхэн бөглөх талаар танилцуулга хийв. Нэмж 5% тараах асуудлыг дэмжих эсэх талаар тайлбарыг өгч хэрхэн тэмдэглэхийг танилцуулж санал хураалтыг эхлүүлэв.

Б.Түвшинбаяр /Хурлын дарга/ - Саналаа өгсөн хувьцаа эзэмшигчид маань түр завсарлаж болно. Завсарлага 10 мин.

Б.Түвшинбаяр /Хурлын дарга/ - Завсарлага дууссан тул тооллогын комиссын тогтоолыг танилцуулна.

С.Одонтуяа /Тооллогын комиссын дарга/ - Тооллогын комиссын тогтоол, тэмдэглэлийг уншиж танилцуулав.

Б.Түвшинбаяр /Хурлын дарга/ - Тооллогын комиссын тогтоолыг сонслоо баярлалаа. Одоо та бүхэнд ээлжит бус хурлаас гарах тогтоолын төслийг уншиж танилцуулавал:

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.15-р заалт, 76-р зүйлийн 76.1.12-р заалт, ээлжит бус хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2013 оны жилийн эцсийн ногдол ашгийг 5%-иар нэмэгдүүлж нэгж хувьцаанд 59 /тавин есөн/ төгрөгөөр нэмж тооцож хуваарилахыг хуралд оролцогчдын 100 %-ийн саналаар зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулахыг гүйцэтгэх захирал /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

Хурлын дарга Б.Түвшинбаяр гэсэн байна. Тогтоолын төсөлтэй холбоотой санал байна уу. Хэрэв санал байхгүй бол тогтоолын төслийг батлах саналтай хувьцаа эзэмшигчид саналаа өгнө үү. За нийт хуралд оролцогсодын 100%-ийн саналаар уг тогтоолыг баталлаа. Баярлалаа.Өнөөдрийн хурлын хэлэлцэх асуудал үүгээр дуусч байна. Хүрэлцэн ирсэн та бүхэнд дахин баярлалаа.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн



Ч.Төрмандах

Тэмдэглэлтэй танилцсан

Б.Түвшинбаяр



ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар *01.*

Тавантолгой.

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.15-р заалт, 76-р зүйлийн 76.1.12-р заалт, ээлжит бус хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2013 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хуваарилах ногдол ашгийг 5% нэмэгдүүлж нэгж хувьцаанд 59 /тавин есөн/ төгрөгөөр нэмж тооцон хуваарилахыг хуралд оролцогчдын 100%-ийн саналаар зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд тогтоолын 1-д заасан хэмжээгээр тооцон олгох ажлыг зохион байгуулахыг гүйцэтгэх захирал /Р.Сэдлорж/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Б.ТҮВШИНБАЯР

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

№1

2015-01-23

Өмнөговь аймаг, Цогтэций сум


“Тавантолгой”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 01 тоот тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Хуралд оролцогчдын 100%-ийн саналын дүнгээр 2013 оны ногдол ашгийг 5%-аар нэмэгдүүлэн хувиарлахаар гарсан саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай.

2. Тооллогын комиссын тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан, хувьцаа эзэмшигчдийн саналын дүнг батлуулахыг Тооллогын комиссын дарга /С.Одонтуяа/-д даалгасугай.

Тооллогын комиссын дарга

Гишүүд
1



С.Одонтуяа

Л.Нямжав

Т.Жамбал

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТЭМДЭГЛЭЛ**

№1

2015-01-23

Өмнөговь аймаг, Цогтцэций сум

"Тавантолгой"ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын даргаар С.Одонтуяа, Гишүүд Л.Нямжав, Т.Жамбал нар ажиллалаа.

Хуралд оролцогчдоос 14 санал ирэхээс нийт 14 саналын хуудас ирсэн бөгөөд хүчингүй саналын хуудас байхгүй байна.

Хүчинтэй 14 саналын хуудас нь 2013 оны ногдол ашгийг 5%-аар нэмэгдүүлэн хувиарлахаар гарсан санал байна.

Тэмдэглэл хөтөлсөн



Л.Нямжав